



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.04.02 № 01/339  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т


### ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН ТАНАА

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд гүйцэтгэсэн Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 46 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Ш.ИДЭРЭНЗБААТАР



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/01/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Хөвсгөл аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар Утас:88883317</p> <p>Цахим хаяг: <a href="mailto:Erdnebaatara@audit.gov.mn">Erdnebaatara@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер Б.Тэгшдэлгэр Утас: 99089114</p> <p>Цахим хаяг: <a href="mailto:Tegshdelgerb@audit.gov.mn">Tegshdelgerb@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор Б.Давааням Утас: 92113932</p> <p>Цахим хаяг: <a href="mailto:davaanyamb@audit.gov.mn">davaanyamb@audit.gov.mn</a></p> <p>Аудитор С.Гансүх Утас: 95908400</p> <p>Цахим хаяг: <a href="mailto:Gansukhsa@audit.gov.mn">Gansukhsa@audit.gov.mn</a></p> <p>Аудитор Л.Мандахнаран Утас: 92118277</p> <p>Цахим хаяг: <a href="mailto:Mandakhnaranl@audit.gov.mn">Mandakhnaranl@audit.gov.mn</a></p> <p>Аудитор Г.Ичинхорлоо Утас: 88012671</p> <p>Цахим хаяг: <a href="mailto:ichinkhorlooga@audit.gov.mn">ichinkhorlooga@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**Агуулга**

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан .....	5-7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....	9-10
Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9-18
4. Аудитын тайлан.....	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19-20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20-21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. Аудитын илрүүлэлт .....	21-25
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	26
Хавсралт .....	27-43

**Товчилсон үгийн жагсаалт**

ААН	Аж Ахуй Нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар
ОНӨҮГ	Орон Нутгийн Өмчит Үйлдвэрийн Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Тооноо А/17


Хөвсгөл аймаг

**Аудитын тайлан баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/75 дугаар тушаал, 2018 оны А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх тухай” тушаал, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү нийцлийн аудитын газар, Хөвсгөл аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2023 оны 9 дүгээр сарын 10-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Ш.Идэрбаясгалан/-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Б.Давааням/-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын  
дэргэ Тэргүүлэх аудиторын 2023 оны 4  
дүгээр сарын 20-ны өдрийн А/17. дугаар  
тушаалын хоёрдугаар хэвсгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Албан шаардлагын дугаар	Утга
1	65/A2260439/ХӨА-2023/01/НА-СТА-ТЭЗ	Сахилгын хариуцлага тооцуулах тухай
2	66/A2260439/ХӨА-2023/НА-СТА-ТЭЗ	Зөрчил арилгуулах тухай



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Ш.ИДЭРБАЯСГАЛАН ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мерон сум, Хөвсгөл аймаг 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgui@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.04.01 № 01/338  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аймгийн Засаг даргын 2022 оны А/67 дугаар захирамжаар Орлого бүрдүүлэлт, өр, авлагыг бууруулах, А/144 дугаартай захирамжаар Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулж, бүртгэлгүй хөрөнгүүдийг бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг бүртгэлээс хасах арга хэмжээг тус тус зохион байгуулж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд аймгийн Засаг даргын хяналтад байгаа байгууллагуудаас Соёл, Эрүүл мэнд, Тусгай зориулалтын шилжүүлгийн нийт 130 байгууллага улсын төсөвт шилжсэнтэй холбоотой 13,889.2 сая төгрөгийн бараа материал, 165,872.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь Ерөнхий сайдтай 2022 онд байгуулсан батламж гэрээний хэрэгжилтийг 85.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 04 сарын 20 өдөр

№ 66/АЭЭБ/0439/ХАА-2023/01  
/НА-СТЯ-ТБЗ

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д тодорхойлогдсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн өөрчлөлт оруулж мөрдүүлэх ажлыг зохион байгуулаагүй;
- Түрээсийн орон сууцны эргэлтийн сантай холбоотой Хөгжлийн банк болон иргэдтэй харилцан тохиролцож зээлийн гэрээг байгуулах асуудлыг шийдвэрлээгүй, Хөгжлийн банктай тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй;
- Авлага өр төлбөрийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй санхүүгийн тайланд тусгасан;

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүн шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй бөгөөд "Эрх ба үүрэг", "оршин байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/05 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.7" 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй" гэж заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой зөрчлийг арилгаж биелэлтийг нотлох баримтын хамт 2023 оны 12 дугаар сарын 01-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup> ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрболзолон, ерөнхий Нягтлан бодогч Л.Батжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮБЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР  
АЖЛАХ АУДИТОР: Б.ДАВААНЯМ

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 3-д, тоот Утас: 70384043

17209300000000000000





**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 04 сарын 20 өдөр

№ 65/АЭЭЛ60439/ХӨА-2023/01  
/НА-СТА-ТЭБ

Мөрөн сум

**Сахилгын хариуцлага тооцуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д тодорхойлогдсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд Барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ийн гүйцэтгэх захирал Д.Батчулуун нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд "Эрх ба үрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, зэрэг, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглаварт хугацаанд байгууллагын санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй зөрчилд Барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ийн гүйцэтгэх захирал Д.Батчулуунд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 10-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Уянсрагчаагаар цаалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ӨРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР:

Б.ДАВААНЯМ

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043 172000004.4.00000005

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>54,699,133.3</b>	<b>41,826,910.1</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,119,066.8	19,692,278.5
33	АВЛАГА	9,687,373.8	8,105,477.0
34	УРЬДЧИЛГАА	84,019.8	382,597.4
35	БАРАА МАТЕРИАЛ	22,252,466.5	10,858,319.9
36	НӨӨЦИЙН БАРАА	305,012.5	424,835.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,251,193.8	2,363,402.0
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>303,212,238.2</b>	<b>146,633,803.4</b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,921,116.6	2,432,742.3
37300	Урт хугацаат зээл	1,921,116.6	2,432,742.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	301,291,121.6	144,201,061.1
39200	Биет хөрөнгө	279,612,963.5	130,146,898.5
39300	Биет бус хөрөнгө	21,678,158.1	13,247,726.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0	806,435.8
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>357,911,371.5</b>	<b>188,460,713.4</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>21,173,618.4</b>	<b>22,696,006.8</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,991,564.9	9,381,394.9
41300	Өглөг	9,062,391.8	8,409,032.5
41400	Урьдчилж орсон орлого	929,173.2	972,362.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,182,053.5	13,314,612.0
42200	Урт хугацаат зээл	11,182,053.5	13,314,612.0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>336,737,753.1</b>	<b>165,764,706.6</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>336,697,101.7</b>	<b>165,724,055.1</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	94,800,219.7	37,162,596.9
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0	37,162,596.9
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	41,928,313.7	41,967,927.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	10,640,241.5	15,173,445.7
51200	Хуримтлагдсан үр дүн	122,279,625.7	45,092,440.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67,048,701.0	26,327,645.4
52	Хяналтын бус хувь оролцоо	40,651.5	40,651.5
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>357,911,371.5</b>	<b>188,460,713.4</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>197,681,480.00</b>	<b>84,717,889.80</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	19,202,784.50	24,740,698.20
110	Орлогын албан татвар	11,786,302.40	14,513,667.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	12,578,663.30	14,488,418.10
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-792,360.90	-900,903.90
1103	ААН-ын орлогын албан татвар	0	926,153.50
113	Хөрөнгийн албан татвар	2,647,965.50	2,929,943.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,768,516.60	7,297,087.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	155,397,060.80	42,552,031.00
120	Нийтлэг татварын бус орлого	54,313,089.80	10,732,496.60
121	Хөрөнгийн орлого	108,629.60	1,258,200.30
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	100,975,341.40	30,561,334.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,081,634.70	17,425,160.50
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>139,510,889.10</b>	<b>80,451,755.80</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	139,510,889.10	79,336,213.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	132,649,536.60	67,766,087.90

**Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,552,688.10	13,314,864.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,924,316.60	1,658,159.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,049,994.40	7,781,005.30
2104	Хангамж, бараа материалын зардал	3,963,082.10	15,385,473.60
2105	Нормативт зардал	9,477,103.20	240,715.50
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	1,256,772.30	1,646,425.00
2107	Томилолт, зочны зардал	187,615.20	186,362.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,656,195.50	10,919,242.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,581,769.30	16,633,838.90
212	ТАТААС	1,855,640.90	1,062,694.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,005,711.70	10,507,431.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	1,115,542.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	58,170,590.90	4,266,133.90
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	29,148.80	4,015.40
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,468,665.90	180,489,353.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	39,731,073.80	-176,219,204.50

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	289,059,544.7	-	289,059,544.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,349,990.6	-	5,349,990.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,409,535.3	-	294,409,535.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-580,746.4	-	-580,746.4
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,665,554.1	-	1,665,554.1
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-687.4	-	-687.4
7	Өмчид гарсан өөрчлөлт	1,538,023.8	-	1,538,023.8
8	Зарласан ногдол ашиг	-25,000.0	-	-25,000.0
9	Тайлант үеийн үр дүн	39,731,073.8	-	39,731,073.8
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	336,737,753.1	-	336,737,753.1
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	336,737,753.1	-	336,737,753.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,650,153.4	-	-1,650,153.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	335,087,599.7	-	335,087,599.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	179,281.7	-	179,281.7
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	988,452.0	-	988,452.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	-	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	5,733,577.6	--	5,733,577.6
18	Зарласан ногдол ашиг	-5,000.0	-	-5,000.0
19	Тайлант үеийн үр дүн	176,219,204.5	-	-176,219,204.5
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	165,764,706.6	-	165,764,706.6

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	172,611,394.0	95,800,545.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	19,202,784.5	24,740,698.2
110	Орлогын албан татвар	11,786,302.4	14,513,667.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	12,578,663.3	14,488,418.1

**Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-792,360.9	-880,100.4
1103	ААН-ын орлогын албан татвар	0	905,350.0
113	Хөрөнгийн албан татвар	2,647,965.5	2,929,943.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,768,516.6	7,297,087.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	936,341.3	1,034,744.7
1181	Газрын төлбөр	514,603.2	763,601.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,317,572.1	5,495,257.4
1183	Бусад татвар	0	3,483.6
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>132,072,100.1</b>	<b>65,857,260.4</b>
120	Нийтлэг татварын бус орлого	30,988,129.0	34,037,726.0
121	Хөрөнгийн орлого	108,629.6	1,258,200.3
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	100,975,341.4	30,561,334.1
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>21,336,509.3</b>	<b>5,202,586.7</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>135,350,718.3</b>	<b>86,141,857.7</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>135,350,718.3</b>	<b>86,141,857.7</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>128,493,545.0</b>	<b>68,474,948.6</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,695,393.6	19,462,653.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,456,525.0	3,668,439.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,452,387.6	8,876,394.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,450,389.8	18,149,846.1
2105	Нормативт зардал	4,912,775.2	235,357.2
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	1,591,181.6	1,475,029.7
2107	Томилолт, зочны зардал	188,539.3	157,815.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,213,491.0	9,332,671.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,532,862.0	7,116,741.0
212	ТАТААС	1,855,640.9	1,062,694.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,001,532.4	16,604,214.2
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>37,260,675.6</b>	<b>9,658,687.6</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>940</b>	<b>0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>26,286,449.6</b>	<b>7,232,134.2</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>26,286,449.6</b>	<b>7,232,134.2</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	26,286,449.6	7,232,134.2
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-26,285,509.6</b>	<b>-7,232,134.2</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-2,630,023.7</b>	<b>-2,853,341.7</b>
14	Бусад эх үүсвэр	0	35,247.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,762,905.8	2,396,276.3
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	867,117.8	492,313.2
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>8,345,142.4</b>	<b>-426,788.3</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,773,924.4	20,119,066.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,119,066.8	19,692,278.5

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл Аймгийн Засаг дарга нь төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, хуваарилах, орон нутгийн орлогыг бүрдүүлэх, зарцуулахад хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Хөвсгөл Аймгийн Засаг дарга нь 2022 оныг “Хөдөлмөр зрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх жил” болгон зарласан байна.

Хөвсгөл аймгийн Засаг дарга нь Ерөнхий сайдтай 2022 онд байгуулсан батламж гэрээний хэрэгжилтийг 85.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Аймгийн Засаг дарга нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Аймгийн Засаг дарга нь төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарал хандуулж ажилласан байна.

Тайлант оноос Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой аймгийн Засаг дарга нь өөрийн харьяаны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 312 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын харьяаны байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль улсын төсөвт, Соёлын төв болон Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу тус тус улсын төсөвт шилжсэн байна.

Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь 2022 онд гүйцэтгэх дотоод хяналтын төлөөлөгөөгөө Хөвсгөл аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01 дугаар тогтоолоор батлуулсан байна. Гүйцэтгэсэн дотоод аудитаар нийт 34 байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийж 262.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч ажилласан баримт материалыг аудитын төлөвлөлтийн үе шатанд ирүүлсэн хэдий ч дотоод аудитаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээг нэгтгэн боловсруулж ирүүлээгүй тул төлөвлөлтийн шатанд дотоод хяналтыг үр нөлөө багатай байна гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд Санхүүгийн хяналт аудитын албаны ажлын хэрэгжилтийг хянаж үзэхэд тайлант онд 110 хяналт шалгалтыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс 84 байгууллагад хяналт шалгалт хийж 99.5 сая төгрөгийн 52 төлбөрийн акт тогтоож, 375.5 сая төгрөгийн 43 албан шаардлага, 358 зөвлөмжийг өгч нийт 13.1 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 265 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж ажилласан бөгөөд бусад төлбөрийн акт албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжих хугацаа болоогүй хэрэгжилтийн шатандаа байна.

Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс нь сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/29 тоот захирамжаар батлуулсан байна. Тайлант онд төлөвлөгөөт 14 сум, төлөвлөгөөт бүс 6 сумын төрийн санд дотоод хяналт хийж, 214 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Дотоод хяналтаар төрийн сангуудын хийж гүйцэтгэсэн гүйлгээнүүд, санхүүжилт болон

**Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

тайлагналын хяналт, татварын орлогын бүрдүүлэлт, төлбөр тооцооны хяналт, төсвийн байгууллагын мөнгөн кассын хэрэгжилт, төрийн сангийн баримтын архивын нэгж бүрдүүлэлт зэрэгт хяналт хийж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

Аймгийн Засаг дарга нь санхүүгийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна.

#### Аудитын илрүүлэлт:

Төсвийн байгууллагуудын мөрдөж байгаа хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон хэдий ч Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдсэн хууль тогтоомжуудад нийцүүлэн өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулаагүй, өмнөх оны аудитаар бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах зөвлөмж өгсөн хэдий ч хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасан цаглаварт хугацаанд бэлтгэж ирүүлсэн байна. Ирүүлсэн тайланг төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх заалтад заасан иж бүрдлийг хангаж байгаа эсэхийг хянахад дараах алдаа зөрчил илэрч байна. **Үүнд:**

Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ тодруулга тайланг бэлтгэж ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.5 "санхүүгийн тайлангийн тодруулга" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайланг хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайланг оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 188,460.7 сая төгрөг болж өмнөх оноос 169,450.7 сая төгрөгөөр буурсан байна.

#### *Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20,019.1	19,692.3	(326.8)
Авлага	9,687.4	8,105.5	(1,581.9)
Урьдчилгаа	84.1	382.6	298.5
Бараа материал	22,252.5	10,858.3	(11,394.2)
Нөөцийн бараа	305.0	424.8	119.8
Бусад эргэлтийн хөрөнгө	2,251.2	2,363.4	112.2
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,921.1	2,432.7	511.6

**Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Үндсэн хөрөнгө	301,291.1	144,201.1	(157,090.0)
Нийт хөрөнгө	<b>357,911.4</b>	<b>188,460.7</b>	<b>(169,450.7)</b>
Өр төлбөр	21,173.6	22,696.0	1,522.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	336,737.7	165,764.7	(170,973.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>357,911.4</b>	<b>188,460.7</b>	<b>(169,450.7)</b>

*Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 169,450.7 сая төгрөгөөр буурахад авлагын үлдэгдэл 1,581.9 сая төгрөгөөр, бараа материалын үлдэгдэл 11,394.2 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн үлдэгдэл 157,090.0 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан байна. Энэ нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж хаалтын тайлан гаргасантай холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт**

Өмчийн өөрчлөлтийн тайлантай холбоотой дараах алдаа илэрсэн. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанаас Улсын төсөвт шилжсэн байгууллагуудын хаалтын тайланг нэгтгэхдээ хуримтлагдсан үр дүн дансыг 10,427.9 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн
- Түнэл сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өмчийн өөрчлөлтийн тайланд өмчид гарсан өөрчлөлтийг 5.8 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн.
- ТЕЗ-ийн өмчийн өөрчлөлтийн тайланд 14.1 сая төгрөгийн зарласан ногдол ашгийг зөрүүтэй нэгтгэсэн.

Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журмын 4.2.1 дахь заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын хугацаанд өмчийн өөрчлөлтийн тайлангийн нэгтгэлтэй холбоотой нийт 10,062.8 сая төгрөгийн алдааг бүрэн залруулсан.

**3.4.1 Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 19,692.2 сая төгрөг болж, өмнөх оноос 426.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	1.2	7.5	6.4
Банканд байгаа бэлэн мөнгө	20,117.9	19,684.7	(433.2)
Төгрөг	20,117.9	19,684.7	(433.2)
Гадаад валют	0.0003	-	(0.0003)
<b>Дүн</b>	<b>20,119.1</b>	<b>19,692.2</b>	<b>(426.9)</b>
Үүнээс: байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	6,686.2	4,960.9	-1,725.4
Төсөл/ сан	3,843.0	3,603.5	-239.5
Төрийн сан	7,521.6	9,456.4	1,934.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,068.3	1,671.5	-396.8
<b>Дүн</b>	<b>20,119.1</b>	<b>19,692.2</b>	<b>(426.9)</b>

*Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийг байгууллагын төрлөөр нь авч үзвэл Төсөвт байгууллагуудын дансны үлдэгдэл 1,725.4 сая төгрөгөөр, төсөл сангийн дансны үлдэгдэл 239.5 сая төгрөгөөр, ТӨҮГ болон ОНӨҮГ-ын дансны үлдэгдэл 36.8 сая төгрөгөөр буурч, төрийн сангийн дансны үлдэгдэл 1,934.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос буурахад 426.9 сая төгрөгөөр бурахад эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэл үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоотой болж улсын төсөвт шилжсэн нь нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

Аудитаар мөнгөн хөрөнгө данстай холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 8,089.6 сая төгрөг болж, өмнөх оноос 1,581.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	58.5	41.4	(17.1)
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,656.1	6.9	(1,649.2)
Зээлийн хүүгийн авлага	152.6	183.6	31.0
Дансны авлага /ТӨҮГ/	2,231.9	1,684.8	(547.1)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	90.5	119.2	28.7
Байгууллагаас авах авлага	2,987.4	3,328.4	341.0
Хувь хүмүүсээс авах авлага	391.8	577.8	186.0
Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	2,228.6	1,919.9	(308.7)
Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээлийн авлага		243.6	243.6
<b>Дүн</b>	<b>9,687.4</b>	<b>8,105.5</b>	<b>1,581.9</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эхний үлдэгдэл 9,687.4 сая төгрөг байсан бөгөөд тайланд онд 1,581.9 сая төгрөгөөр буурсан байна. Авлагыг төрлөөр нь авч үзвэл төлбөртэй үйлчилгээний авлага 1,649.2 сая төгрөгөөр, ТӨҮГ-ын дансны авлага 547.1 сая төгрөгөөр, хувь хүмүүст олгосон зээлийн авлага 308.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Авлагын үлдэгдэл буурахад төлбөртэй үйлчилгээний авлага нийт дүнгээрээ 1,649.2 сая төгрөгөөр, Могойн гол ХХК-ийн борлуулалтын авлага болон уурхайн тоног төхөөрөмжтэй холбоотой авлага нийт 57.6 сая төгрөгөөр, "Хөвсгөл эрчим хүч" ХХК-ийн гэрэл цахилгааны төлбөрийн авлага 461.8 сая төгрөгөөр, "Хөвсгөл ус суваг" ХХК-ийн цэвэр бохир усны төлбөрийн авлага 109.4 сая төгрөгөөр хасагдсан нь нөлөөлсөн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын эхний үлдэгдэл 2,118.6 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 44.9 сая төгрөгөөр нэмэгдэж 2,163.5 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 296 иргэнтэй холбоотой 1,227.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт

Татаас санхүүжилтийн авлага дансны хоорондын тооцооны бичилтийг дутуу хийсэн. Үүнд:

- Мал хамгаалах сан 7.1 сая төгрөг,
- Байгаль орчин аялал жуулчлалын газар 127.2 сая төгрөг,
- Аймгийн Засаг даргын Тамгын газар 4.1 сая төгрөг

Дансны авлага /ТӨҮГ/ дансанд Могойн гол ХК-ийн авлагыг аудит хийсэн санхүүгийн тайлангаас 170.5 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн.

Сангийн яамнаас дамжуулан зээлдүүлэх гэрээний төлбөрийг аймагт олгох санхүүгийн дэмжлэгээс суутгасан 416.5 сая төгрөгийг Орон нутгийн ерөнхий орлого дансанд авлага үүсгэхдээ холбогдох талуудаас авлага үүсгээгүй зэрэг алдаа илэрсэн.

Дээрх алдаа нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах тодруулга бэлтгэх журмын 4.2.2 дахь заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Аудитын хугацаанд бүртгэл тайлагналтай холбоотой нийт 725.5 сая төгрөгийн алдааг залруулсан.

#### Аудитын илрүүлэлт:



Малжуулах төслөөс иргэдэд олгосон зээлийн авлагатай холбоотой 108.2 сая төгрөгийг 2022 онд сангийн яамнаас орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгээс хасаж шилжүүлсэн тул 108.2 сая төгрөгийг хувь хүмүүсээс авах авлагаар бүртгэсэн ч тооцоо нийлсэн актаар баримтжуулаагүй байна. Олон жил болсон бөгөөд барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Шүүхийн шийдвэр гарж ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь тогтоогдож Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг төсвөөс олгож буруутай албан тушаалтнаас авах авлагаар бүртгэсэн хэдий ч байгууллагад учирсан хохирлыг барагдуулаагүйтэй холбоотой 115.2 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2. "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. /Хаэсралт №3-аас харах/

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 382.6 сая төгрөг болж, өмнөх оноос 298.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	84.0	382.6	298.6
Дүн	84.0	382.6	298.6

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 84.0 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 298.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Могойн гол ХХК-ийн урьдчилж төлсөн зардалтай холбоотой байна. Үүнд: Өрмийн машины урьдчилгааны зардалд Гранд манинг ХХК-д төлсөн 70.0 сая төгрөг, ТУАСИА ХХК-д экскаватор түрээслэх зардалд 181.0 сая төгрөг, эмч нарын холбоонд ажилчдын эрүүл мэндийн үзлэгийн зардалд 15.0 сая төгрөгийг урьдчилж шилжүүлсэн зэргээс хамаарч урьдчилгаа дансны үлдэгдэл нэмэгдсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

Урьдчилгаа дансанд Могойн гол ХХК-ийн аудит хийсэн тайлангийн дүнгээс урьдчилж гарсан зардлыг 111.8 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэн тайлагнасан. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журмын 4.2.1 дахь заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Аудитын хугацаанд бүртгэл тайлагналтай холбоотой нийт 111.8 сая төгрөгийн алдааг залруулсан.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 10,858.3 сая төгрөг болж, өмнөх оноос 11,394.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	2,798.3	525.4	(2,272.9)
Тусгай зориулалттай материал	1,128.6	408.3	(720.3)

**Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Эм боох материал	1,669.3	117.1	(1,552.2)
Дуусаагүй үйлдвэрлэл	735.7	7.5	(728.2)
Бэлэн бүтээгдэхүүн	2,704.2	3,656.5	952.3
<b>Хангамжийн материал</b>	<b>15,643.4</b>	<b>6,430.3</b>	<b>(9,213.1)</b>
Бичиг хэргийн материал	367.4	77.9	(289.5)
Аж ахуйн материал	4,111.5	1,620.2	(2,491.3)
Сэлбэг хэрэгсэл	577.2	701.7	124.5
Түлш, шатах тослох материал	1,032.4	564.4	(468.0)
Барилгын засварын материал	443.3	45.5	(397.8)
Хүнсний материал	940.7	2.8	(937.9)
Бусад хангамжийн материал	8,170.9	3,417.9	(4,753.0)
Мал амьтад	305.0	238.5	(66.5)
<b>Дүн</b>	<b>22,252.5</b>	<b>10,858.3</b>	<b>(11,394.2)</b>

*Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Тайлант онд түүхий эд материал нийт 2,272.9 сая төгрөгөөр, хангамжийн материал 9,213.1 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материал дансны үлдэгдэл нийт дүнгээрээ буурахад Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн нийт 130 байгууллага улсын төсөөт шилжсэнтэй холбоотой нийт 13,889.2 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг үнэ төлбөргүй шилжүүлэн бүртгэсэн, Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой бараа материалын нөөц үүсгэхгүй ажилласан зэрэгтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт**

*Аудитаар бараа материалын данстай холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.*

**3.5.5.1 Нөөцийн бараа**

Нөөцийн бараа дансны эцсийн үлдэгдэл 424.8 сая төгрөг болж, өмнөх оноос 119.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 6. Нөөцийн барааны үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	68.5	170.4	101.9
Тэжээлийн нөөц	236.4	254.4	18.0
<b>Дүн</b>	<b>305.0</b>	<b>424.8</b>	<b>119.8</b>

*Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Нөөцийн барааны үлдэгдэл өмнөх оноос 119.8 сая төгрөгөөр нэмэгдэхэд Цагаар-үүр сумын ЗДТГ-ын өвс тэжээлийн нөөц 102.6 сая төгрөгөөр, Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн 67.9 сая төгрөгийн материалын нөөц, Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн нөөц 242.7 төгрөг, Жаргалант сумын ЗДТГ-ын өвс тэжээлийн нөөц 11.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт**

*Аудитаар нөөцийн бараа материалын данстай холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.*

**3.5.5.2 Бусад эргэлтийн хөрөнгө**

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 2,363.4 сая төгрөг болж, өмнөх оноос 112.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	2,251.2	2,363.4	112.2
<b>Дүн</b>	<b>2,251.2</b>	<b>2,363.4</b>	<b>112.2</b>

*Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 112.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Засаг дарга дансанд бүртгэлтэй 448.6 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, орон нутгийн хөрөнгө

**Хөөсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

оруулалт 169.4 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 394.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна. Энэ нь хөрөнгө оруулалтаар нийгдсэн ажлууд бүрэн хэрэгжиж дуусаагүйгээс хөрөнгүүдийг ашиглагч байгууллагад шилжүүлэн өгөөгүйтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт**

*Накора сангийн төслийн үйл ажиллагаа хэрэгжиж дууссан хэдий ч хаалтын тайлан гаргаагүй, бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 512.5 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагад нь шилжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3." дуусгалтын тайлан" гаргах гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Тасалбар болголт" гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Дуусгалтын тайланг гаргаж, өмчийн асуудлыг шийдвэрлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн*

**3.5.5.3 Урт хугацаат хөрөнгө оруулалт**

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 2,432.7 сая төгрөг болж, өмнөх оноос 511.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 8. Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Хувь хүмүүст олгосон зээл	1,921.1	2,022.8	101.7
Хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл	-	409.9	409.9
<b>Дүн</b>	<b>1,921.1</b>	<b>2,432.7</b>	<b>511.6</b>

*Эх сурвалж: Хөөсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн нь хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд 2,072.1 сая төгрөгийн зээлийг олгож урт богино хугацаагаар нь ангилан бүртгэсэнтэй холбоотой байна. Хоршоо хөгжүүлэх сангийн журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 13 дугаар сарын 13-ны өдрийн 361 дугаар тушаалаар баталсантай холбоотой иргэн, аж ахуй нэгж, хоршоодод зээлийг иргэнд 20.0 сая төгрөг, аж ахуй нэгжид 60.0 сая хүртэлх дүнгээр олгох болсон байна.

**Аудитын илрүүлэлт**

*Аудитаар урт хугацаат хөрөнгө оруулалт данстай холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.*

**3.5.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 144,201.1 сая төгрөг болж, өмнөх оноос 157,090.0 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>279.6</b>	<b>130.2</b>	<b>(149.4)</b>
Барилга, байгууламж, орон сууц	243,790.9	95,649.9	(148,141.0)
Авто-тээврийн хэрэгсэл	12,544.7	12,927.2	382.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	26,197.3	16,663.8	(9,533.5)
Тавилга, аж ахуйн ад хогшил	9,166.5	2,215.2	(6,951.3)
Зам гүүрний байгууламж	19,755.3	19,767.5	12.2
Түүх сочлын дурсгалт зүйлс	1,322.0	239.4	(1,082.6)
Бусад үндсэн хөрөнгө	18,022.7	14,064.4	(3,958.3)
Дуусаагүй барилга, байгууламж	7,638.0	9,662.8	2,024.8
Ном	2,072.3	550.6	(1,521.7)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>21,678.2</b>	<b>13,247.7</b>	<b>(8,430.5)</b>
Программ хангамж	484.4	261.1	(223.3)

**Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Бусад биет бус хөрөнгө	21,459.4	13,198.7	(8,260.7)
<b>Бусад хөрөнгө /ТӨҮГ/</b>		<b>806.4</b>	<b>806.4</b>
Биологийн хөрөнгө /ТӨҮГ/		782.0	782.0
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/		24.4	24.4
<b>Дүн</b>	<b>301,291.1</b>	<b>144,201.1</b>	<b>(157,090.0)</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 149.4 сая төгрөгөөр, биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 8,430.5 сая төгрөгөөр буурч, бусад хөрөнгө дансны үлдэгдэл 806.4 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нийт дүнгээрээ буурахад Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн нийт 130 байгууллага улсын төсөвт шилжсэнтэй холбоотой 165,872.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр үнэ төлбөргүй шилжүүлэн бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

Биет хөрөнгө дансанд Могойн гол ХК-ийн аудит хийсэн тайлангаас 62.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг мөр мөрөөр нь нэгтгэх горимыг баримтлаагүй зөрүүтэй нэгтгэсэн.

Биет бус хөрөнгө дансанд Могойн гол ХК-ийн 19.5 төгрөгийг аудит хийсэн тайлангийн дүнгээс зөрүүтэй нэгтгэсэн байна.

Дээрх алдаа нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах тодруулга бэлтгэх журмын 4.2.2 дахь заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Үндсэн хөрөнгө дансны бүртгэл тайлагналтай холбоотой нийт 81.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

**3.5.7 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 22,696.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,522.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>9,991.6</b>	<b>9,381.4</b>	<b>(610.2)</b>
Ажилчидтай холбогдсон өглөг	459.1	30.0	(429.1)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	459.1	46.9	(412.2)
Татаас санхүүжилтийн өглөг	-	0.2	0.2
Зээлийн хүүгийн өглөг	551.4	544.1	(7.3)
Байгууллагад төлөх өглөг	5,146.3	5,414.6	268.3
Хувь хүмүүст төлөх өглөг	1,448.1	1,961.9	513.8
Татварын өглөг /ТӨҮГ/	501.7	204.7	(297.0)
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	126.0	5.1	(120.9)
Дансны өглөг /ТӨҮГ/	799.7	201.6	(598.1)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	41.5	42.2	0.7
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	0.2		(0.2)
Бусад урьдчилж орсон орлого	887.5	930.2	42.7
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>11,182.1</b>	<b>13,314.6</b>	<b>2,132.5</b>
Хувь хүмүүсийн зээл	108.2	108.2	-
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	2,885.8	2,885.8	-
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/		51.9	51.9
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	793.2	793.2	-
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	7,394.9	9,475.6	2,080.7
<b>Дүн</b>	<b>21,173.6</b>	<b>22,696.0</b>	<b>1,522.4</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд “Хөвсгөл Эрчим хүч” ХХК-ийн өр төлбөр 1,008.5 сая төгрөг, “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 1,877.3 сая төгрөгийн үлдэгдэл байгаа ба энэ нь Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны төслийн зээлийн үлдэгдэл байна.

Хөвсгөл аймгийн Засаг дарга, Сангийн яамтай байгуулсан MON7313 гэрээний дагуу 7,394.9 сая төгрөгөөр Хөвсгөл аймагт цэвэрлэх байгууламж барьсан гэрээний дүнг орон нутгийн төсвөөс төлж барагдуулах гэрээ хийсэн байна. Тайлант онд Хөвсгөл ус суваг ХХК-ийн цэвэрлэх байгууламжийн өр төлбөрийн дүн валютын ханшийн зөрүүнээс хамаарч 2,080.7 сая төгрөгөөр нэмэгдэж нийт 9,475.6 сая төгрөг болсон байна.

**Аудитын илрүүлэлт:**

*Татварын өглөг дансанд Могойн гол ХК-ийн 2.0 сая төгрөгийн өглөг, Дансны өглөг дансанд 3.6 сая төгрөгийн өглөгийг нэгтгэхдээ мөр мөрөөр нэгтгэх горимыг баримтлаагүй зөрүүтэй нэгтгэсэн.*

*Түрээсийн орон сууцны төлбөрт иргэдээс байрны төлбөрт хүлээн авсан 485.3 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасныг бууруулж өглөгөөр хүлээн зөвшөөрүүлж залруулга хийлгэсэн.*

*Дээрх алдаа нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах тодруулга бэлтгэх журмын 4.2.1, 4.2.2 дахь заалттай нийцэхгүй байгаа бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна*

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад өглөгийн дансанд бүртгэл тайлагналтай холбоотой нийт **490.8 сая төгрөгийн алдааг залруулсан.**

**Аудитын илрүүлэлт:**

*Барьцаа хөрөнгө дансанд 2,866.0 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байгаа ба тус өр төлбөрийг ямар харилцагчид өгөх нь тодорхойгүй тооцоо нийлсэн баримтгүй байна.*

*Мал хамгаалах сангаас ААН, байгууллагад өгсөн өөс, тэжээлийн чанар муу, хэрэглэх боломжгүй тул өглөгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай мэдээлэл байна. Тухайлбал Улаан-Уул, Рэнчинлхүмбэ, Цагаан-Уул сумын ЗДТГ-ууд байна. Санхүүгийн байдлын тайланд ААН, байгууллагад өгсөн өөс, тэжээлийн 64.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүйгээр тайланд тусгасан байна.*

*Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хоригоно” 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

**Шийдвэрлэсэн нь:** Үүссэн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, бүртгэл тайланд тусгах зөвлөмж хүргүүлсэн

**3.5.10 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 165,764.7 сая төгрөг болж, өмнөх оноос 170,973.0 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	336,697.1	165,724.1	170,973.0
Засгийн газрын оруулсан капитал	94,800.2	37,162.6	(57,637.6)
Өмч /төрийн/ /ГӨҮГ/	41,928.3	41,967.9	39.6
Эздийн өмчийн бусад хэсэг /ГӨҮГ/	10,640.2	15,173.4	4,533.2
Хуримтлагдсан үр дүн	122,279.6	45,092.4	77,187.2
Өмнөх үеийн үр дүн	82,548.6	221,311.6	138,763.1
Тайлант үеийн үр дүн	39,731.1	(176,219.2)	(218,950.3)

**Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	67,048.7	26,327.6	(40,721.1)
Хяналтын бус хувь оролцоо	40.7	40.7	-
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>336,737.7</b>	<b>165,764.7</b>	<b>170,973.0</b>

*Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 170,973.0 сая төгрөгөөр буурахад тайлант үеийн үр дүн 218,950.3 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 77,187.2 сая төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 40,721.1 сая төгрөгөөр засгийн газрын оруулсан капитал 57,637.6 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан байна. Энэ нь Боловсрол, Соёл, эрүүл мэндийн байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт шилжиж хөрөнгө материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн бүртгэж хаалтын тайлан гаргасантай холбоотой байна.

**Орлогын данс**

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 84,717.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 112,963.6 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 12 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого*

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөг/ зөрүү
Татварын орлого	19,202.8	24,740.7	5,537.9
Татварын бус орлого	155,397.1	42,552.0	(112,807.8)
Тусламж санхүүжилтийн орлого	23,081.6	17,425.2	5,656.4
<b>Нийт дүн</b>	<b>197,681.5</b>	<b>84,717.9</b>	<b>(112,963.6)</b>

*Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь тусгай зориулалтын шилжүүлгийн, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж улсын төсвөөс авах санхүүжилт хасагдсанаас шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 85,175.4 сая төгрөгийн орлогын давхардсан 768 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 82,418.0 сая төгрөгийн орлогын давхардсан 649 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

**Аудитын илрүүлэлт:**

*Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон 4,168.6 сая төгрөгийн санхүүжилтийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих дансанд бүртгэж зөрүүтэй тайлагнасан.*

*Ахмадын асрамж үйлчилгээний төвийн 441.8 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвийн санхүүжилт гэж алдаатай нэгтгэн тайлагнасан.*

*Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 8.3 сая төгрөгийн шилжүүлгийг устгах бичилт хийгээгүй.*

*Барьцаа хөрөнгийн данснаас шилжүүлсэн 707.8 сая төгрөгийн хоорондын тооцооны устгах бичилтийг бүрэн хийгээгүй тайлагнасан.*

*Хөвсгөл эрчим хүч ХХК борлуулалтын орлого данснаас төсвийн шууд захирагчдын гэрэл цахилгааны өглөг дансанд хийх 999.9 сая төгрөгийн устгах бичилтийг хийгээгүй.*

*Хөвсгөл Ус суваг ХХК-ийн төсвийн шууд захирагчидтай хийсэн хоорондын тооцооны бичилтийг 535.2 сая төгрөгөөр дутуу хийсэн.*

*Засаг дарга данснаас олгосон 1,095.9 сая төгрөгийн хоорондын тооцооны бичилтийг дутуу бүртгэж тайлагнасан.*

*Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр арга хэмжээний дүнд бий болсон хөрөнгөтэй холбоотой 2,156.4 сая төгрөгийн орлого, зардлын давхардсан гүйлгээний устгах бичилтийг хийгээгүй.*

*Дээрх алдаа нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах тодруулга бэлтгэх журмын 4.2.1, 4.2.2 дахь заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь:

Аудитын хугацаанд орлогын данс болон хоорондын тооцооны устгах бичилттэй холбоотой нийт 10,113.9 сая төгрөгийн алдааг бүрэн залруулсан.

**Зардлын данс**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 80,414.4 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Хүснэгт № 13: Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөг/ зөрүү
Бараа ажил үйлчилгээний зардал	132,649.5	67,728.8	(64,920.7)
Урсгал шилжүүлэг	5,005.7	10,507.4	5,501.7
Татаас	1,855.6	1,062.7	(792.9)
Хөрөнгийн зардал	-	1,115.5	1,115.5
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>139,510.9</b>	<b>80,414.4</b>	<b>(59,096.4)</b>

Эх сурвалж: Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт зардал өмнөх өнд 139,510.9 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 73,053.7 сая төгрөг болж 66,457.2 сая төгрөгөөр буурахад тусгай зориулалтын шилжүүлгийн, Соёл, Эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж орон нутгаас байр ашиглалтын зардлыг санхүүжүүлэх болсноор төсвийн зардал буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 85,175.4 сая төгрөгийн зарлагын давхардсан 768 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 82,418.0 сая төгрөгийн зарлагын давхардсан 649 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

Зардлын данс болон хоорондын тооцооны устгах бичилттэй холбоотой дараах алдаа илэрсэн. Үүнд:

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг /Баянзүрх, Улаан-Уул/ 4.9 сая төгрөгийг устгах бичилт хийгээгүй.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг /БТСХ/ 0.5 сая төгрөгийг устгах бичилт хийгээгүй тайлагнасан.

Нийтийн номын сангийн төвлөрүүлсэн 9.4 сая төгрөгийн шилжүүлгийг үйл ажиллагааны үр дүнгээр тайлагнасан.

Нийтийн номын сангийн төвлөрүүлэх шилжүүлэг 0.3 сая төгрөгийг үйл ажиллагааны үр дүнгээр тайлагнасан.

Хөвсгөл эрчим хүч ХХК нь борлуулалтын орлогыг байгууллагуудтай улсын төсвийн санхүүжилт дансанд 134.8 сая төгрөгийн устгах бичилт алдаатай бүртгэж, тайлагнасан.

Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилтийг 14.1 сая төгрөгөөр дутуу хийсэн.

Дээрх алдаа нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах, тодруулга бэлтгэх журмын 4.2.2 дахь заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын хугацаанд бүртгэл тайлагнал болон хоорондын тооцооны устгах бичилттэй холбоотой нийт 163.5 сая төгрөгийн алдааг залруулсан.

**4. АУДИТЫН ТАЙЛАН**

**4.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай *дотоод хяналт*, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Б.Давааням, аудитор С.Гансүх, Л.Мандахнаран, Г.Ичинхорлоо нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 2/517 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн 197,681.5 сая төгрөгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 1.5 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 2,965.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,223.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүн 84,755.2 сая төгрөгийг сонгож 953.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгийн Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт орлогын дүн буурсантай холбоотой материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоох шаардлагатай болсон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтад байгаа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 326.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Илэрсэн зөрчлийг орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээлэх 151 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, бусад мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Харьяа байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар 2,220.2 сая төгрөгийн зөрчил, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитаар 6,149.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд тухай бүр нь холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэн ажилласан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**



**Түрээсийн орон сууцтай холбоотой асуудал:** Худалдаа хөгжлийн банканд 2020-2021 онд нийт 1,616.8 сая төгрөг шилжүүлснийг нь Хөгжлийн банк хүү болон алдангид 1,437.8 сая төгрөг, 178.9 сая төгрөгийг үндсэн зээлээс хассан байна. Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тогтоолоор МУ-ын Хөгжлийн банканд төлөх зээлийн эргэн төлөлтийг түр түдгэлзүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн удирдлагууд зээлийн гэрээнд туссан хүү, алдангийг төлөх боломжгүй гэж үзэн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг байгуулан БХБ-ын сайд, орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, Сангийн сайд, Хөгжлийн банканд удаа дараа албан тоот хүргүүлсэн боловч үр дүн гараагүй байна.

"Түрээсийн болон орон сууцны эргэлтийн сан" 135 орон сууцыг түрээслэгчийн 14 түрээслэгчтэй гэрээ байгуулж баталгаажуулсан ба дээрх гэрээнд өөрчлөлт оруулах асуудал тодорхойгүй, оршин суугчидтай ойлголцохгүй байгаагаас 121 түрээслэгчтэй гэрээ байгуулаагүй бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Энэ "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна..

**Шийдвэрлэсэн нь:** Хөгжлийн банкт байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулж, оршин суугчидтай тохиролцож орон сууц худалдах гэрээг байгуулах ажлыг зохион байгуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

**Могойн гох ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудал:** Хувьцаа эзэмшигчдийн хурал нь 2022 онд Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг эцэслэн шийдэж чадаагүйгээс компани нь бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн чадамжгүй 2 төлөөлөн удирдах зөвлөлтэй болж эдгээрээс гарсан шийдвэр нь эрх зүйн үндэслэлтэй шийдвэр болохгүй байна. Компанийн дээд удирдлагын үйл ажиллагаа доголдоноос шалтгаалсан санхүүгийн үйл ажиллагааны зөрчил нэмэгдсэн бөгөөд 2022 оны санхүүгийн тайланд "Сөрөг" санал дүгнэлт авсан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

**Хөрөнгийн бүртгэл, хяналттай холбоотой асуудал:** Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн жагсаалтыг байгууллага тус бүрээр нь нэгтгэн гаргасан бүртгэл тооцоо байхгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2. "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Засаг даргын 2022 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,955.0 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж 2 албан шаардлагыг өгсөн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		/сая төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2		2		100
Зөвлөмж	8	7,955.0	5	4,817.5	62.5
Нийт дүн	10	7,955.0	7	4,817.5	70.0

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжүүдээс НБББББ-ийг шинэчлэх, Түрээсийн орон сууцтай холбоотой зээлийн гэрээг байгуулах, авлага өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 70.0 хувьтай биелүүлсэн гэж дүгнэлээ.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" албан шаардлага өгнө гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан нь Сангийн яамны Э-тайлан программын алдаанаас шалтгаалж орлого үр дүнгийн тайланд татварын бус орлогоос Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн борлуулсан барааны өртгийг хасаж тусгаснаас орлого болон зардлын нийт дүнг 24,392.9 сая төгрөгөөр бууруулж тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.3.1 "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" заалттай нийцэхгүй байгаад анхаарал хандуулах нь зүйтэй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:**

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 3,666.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Аудитаар илэрсэн 3,666.3 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж, 2 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

**Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:** Аймгийн Засаг даргын харьяа 24 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан ба Төмөрбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт гаргаж, бусад төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 12,191.9 сая төгрөгийн алдаа, 3,519.0 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс аудитын хугацаанд 12,191.9 сая төгрөгийн 26 алдааг залруулж, 28.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, 3,491.0 сая сая төгрөгийн зөрчилд 53 зөвлөмж хүргүүлсэн. /Хавсралт №2-оос харах/

**Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар:** Аудитаар нийт 105 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж, 74 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 32 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль журмын хэрэгжилттэй холбоотой 2,761.0 сая төгрөгийн алдаа, 3,040.5 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 2,761.0 сая төгрөгийн алдааг залруулж, 142.5 сая төгрөгийн зөрчилд 22 төлбөрийн акт тогтоож, 1,362.8 сая төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага, 489.9 сая төгрөгийн зөрчилд сахилгын хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгч, 1,045.3 сая төгрөгийн зөрчилд 42 зөвлөмж хүргүүлсэн. /Хавсралт №2-оос харах/

**Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудитын талаар:**

Аудитаар нийт 29 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжийн санхүүгийн тайланд аудит хийж, 13 байгууллагын санхүүгийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж, 16 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль журмын хэрэгжилттэй холбоотой 1,848.5 сая төгрөгийн алдаа, 9,165.5 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс аудитын хугацаанд 1,848.5 сая төгрөгийн 16 алдааг залруулж, 54.4 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 3,789.6 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, зөрчил гаргасан албан хаагчид хариуцлага тооцуулах 1 албан шаардлага өгч, 5,321.5 сая төгрөгийн зөрчилд 65 зөвлөмж хүргүүлсэн. /Хавсралт №2-оос харах/

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2022 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар "Хязгаарлалттай" санал дүгнэлт 4, "Сөрөг" санал дүгнэлт 1-ийг гаргасан байна. Бусад аудитад хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт гаргасан.

Зөрчилтэй санал дүгнэлт авсан байгууллагуудыг харуулбал:

№	Байгууллагын нэр	Санал дүгнэлтийн төрөл
1	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Хязгаарлалттай
2	Цагаан-Үүр сумын ЗДТГ	Хязгаарлалттай
3	Шинэ Мөрөн худалдааны төв ОНӨ ХХК	Хязгаарлалттай
4	Төмөрбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	Хязгаарлалттай
5	Могойн гол ХХК	Сөрөг

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой нийт 12,828.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 363.1 сая төгрөгийн материаллаг, 12,464.9 сая төгрөгийн материаллаг бус зөрчил байна. ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 287.7 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн.

#### 4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулсан алдаа

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 22,145.4 сая төгрөгийн 27 алдааг /хавсралт №1-ээс харах/ илрүүлж залруулсан болно. Үүнд:

- Аймгийн Засаг даргын харьяаны байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага зэрэг үзүүлэлтүүдийг мөр мөрөөр нь нэмэх байдлаар нэгтгэх горимыг баримтлаагүйтэй холбоотой 6,066.1 сая төгрөгийн 16 алдаа<sup>1</sup>;
- Нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын хоорондын авлага, өглөг, орлого болон зардлын ажил гүйлгээг бүрэн устгаж цэвэр дүнгээр тайлагнаагүйтэй холбоотой 5,651.4 сая төгрөгийн 10 алдааг<sup>2</sup>;
- Аймгийн Засаг даргын харьяаны байгууллагуудаас улсын төсөвт шилжиж хаалтын тайлан гаргасантай холбоотойгоор 10,427.9 сая төгрөгийн алдааг<sup>3</sup>;

Дээрх алдаа нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журмын 4.2.1, 4.2.2 дахь заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 5.1 Төлбөрийн акт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

#### 5.2 Албан шаардлага

##### 1. Санхүүгийн тайланг хугацаанд нь ирүүлээгүйтэй холбоотой асуудал

- "Барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨҮГ нь Санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглаварт хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байна. Энэ нь "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд "Барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨҮГ-ын удирдлагад Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх заалтыг үндэслэн сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

##### 2. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

- **НБББББ-тэй холбоотой асуудал:** Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна. ТЕЗ-ийн мөрдөж байгаа хууль тогтоомж, холбогдох журам заавруудад өөрчлөлт орсон хэдий ч

<sup>1</sup> Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах журмын 4.2.1 дахь заалттай нийцээгүй

<sup>2</sup> Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан ТЕЗ-ийн болон ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах журмын 4.2.2 дахь заалттай нийцээгүй

<sup>3</sup> Сангийн яамны 2022.01.05-ны өдрийн 10/В4 тоот албан бичгээр үрүүлсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлээр ирүүлсэн заавар

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдсэн хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна. Энэ нь НББ тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2."аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- **Түрээсийн орон сууцтай холбоотой асуудал:** Худалдаа хөгжлийн банканд 2020-2021 онд нийт 1,616.8 сая төгрөг шилжүүлснийг нь Хөгжлийн банк хүү болон алдангид 1,437.8 сая төгрөг, 178.9 сая төгрөгийг үндсэн зээлээс хассан байна. Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тогтоолоор МУ-ын Хөгжлийн банканд төлөх зээлийн эргэн төлөлтийг түр түдгэлзүүлсэнтэй холбоотой 2022 онд мөнгө шилжүүлээгүй Түрээсийн орон сууцны дансанд 477.9 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хөвсгөл аймгийн удирдлагууд зээлийн гэрээнд туссан хүү, алдангийг төлөх боломжгүй гэж үзэн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг байгуулан Барилга хот байгуулалтын сайд, орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүд, Сангийн сайд, Хөгжлийн банканд удаа дараа албан тоот хүргүүлсэн боловч үр дүн гараагүй байна.

"Түрээсийн болон орон сууцны эргэлтийн сан" 135 орон сууцыг түрээслэгчийн 14 түрээслэгчтэй гэрээ байгуулж баталгаажуулсан ба дээрх гэрээнд өөрчлөлт оруулах асуудал тодорхойгүй, оршин суугчидтай ойлголцохгүй байгаагаас 121 түрээслэгчтэй гэрээ байгуулж чадаагүй байна. Энэ "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- **Өр, авлагатай холбоотой асуудал:** Өр, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй санхүүгийн тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлүүдэд НБББББ-ийг шинэчлэн боловсруулах, авлага, өглөгийг баталгаажуулах, Хөгжлийн банктэй байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулж, оршин суугчидтай орон сууц худалдах гэрээг харилцан тохиролцож байгуулах албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Тодруулга, тайлантай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ тодруулга тайланг бэлтгэж ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.5 "санхүүгийн тайлангийн тодруулга" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Топилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэж, тайлангийн иж бүрдлийг ханган тайлагнаж байх.

#### 2. Байгууллагад учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхээр тогтоогдож, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг төсвөөс олгож буруутай албан тушаалтнаас авах авлагаар бүртгэсэн хэдий ч байгууллагад учирсан хохирлыг барагдуулаагүйтэй холбоотой 115.2 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2."Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## 2.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн хяналт аудитын албыг Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих

## 3. Төсөл сантай холбоотой асуудал

### 3.1 Илрүүлэлт:

Накора сангийн төсөл хэрэгжиж дууссан хэдий ч хаалтын тайлан гаргаагүй, бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 512.5 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагад нь шилжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3. "дуусгалтын тайлан" гаргах гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Тасалбар болголт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Өгсөн зөвлөмж:

Накора сангийн бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 512.5 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэн бүртгэж хаалтын тайлан гаргах.

## 4.Өр төлбөртэй холбоотой асуудал

### 4.1 Илрүүлэлт:

Барьцаа хөрөнгө дансанд 2,866.0 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байгаа ба тус өр төлбөрийн ямар харилцагчид өгөх нь тодорхойгүй тооцоо нийлсэн баримтгүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 4.2 Өгсөн зөвлөмж:

Өр төлбөрийг харилцагч бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

## 3. Хөрөнгийн бүртгэл, хяналттай холбоотой асуудал

### 3.1. Илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн жагсаалтыг байгууллага тус бүрээр нь нэгтгэн гаргасан бүртгэл тооцоо байхгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2. "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.2 Өгсөн зөвлөмж:

Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийн бүртгэл хөтөлж ажиллах.

## 4. Авлагатай холбоотой асуудал

### 4.1. Илрүүлэлт:

- Малжуулах төслөөс иргэдэд олгосон зээлийн авлагатай холбоотой 108.2 сая төгрөгийг 2022 онд сангийн яамнаас орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгээс хасаж шилжүүлсэн тул 108.2 сая төгрөгийг хувь хүмүүсээс авах авлагаар бүртгэсэн хэдий ч тооцоо нийлсэн актаар баримтжуулаагүй байна. Олон жил болсон бөгөөд барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Хөвсгөл аймгийн Мал хамгаалах сангаас ААН, байгууллагад өгсөн өвс, тэжээлийн чанар муу, хэрэглэх боломжгүй тул өглөгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай мэдээлэл байна.

Тухайлбал Улаан-Уул, Рэнчинлхүмбэ, Цагаан-Уул сумын ЗДТГ-ууд байна. Санхүүгийн байдлын тайланд ААН, байгууллагад өгсөн өвс, тэжээлийн 64.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлээгүй тайлагнасан байна.

**6.2 Өгсөн зөвлөмж:**

Авлагыг харилцагч бүрээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах, үүссэн авлагыг барагдуулах.

**5. Компанийн удирдлага, санхүүтэй холбоотой асуудал**

**5.1. Илрүүлэлт:**

Могойн гол ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал нь 2022 онд Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг эцэслэн шийдэж чадаагүйгээс компани нь бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн чадамжгүй 2 төлөөлөн удирдах зөвлөлтэй болж эдгээрээс гарсан шийдвэр нь эрх зүйн үндэслэлтэй шийдвэр болохгүй байна. Компанийн дээд удирдлагын үйл ажиллагаа доголдоноос шалтгаалсан санхүүгийн үйл ажиллагааны зөрчил нэмэгдсэн бөгөөд 2022 оны санхүүгийн тайланд "Сөрөг" санал дүгнэлт авсан байна.

**7.2 Өгсөн зөвлөмж:**

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, зөрчил дутагдлыг арилгах.

**6. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчилтэй холбоотой асуудал**

**6.1. Илрүүлэлт:**

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой нийт 12.828.1 сая төгрөгийн зөрчил илэрч 51.1 сая төгрөгийн 9 төлбөрийн акт тогтоож, 4.947.4 сая төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага өгч, 7.339.7 сая төгрөгийн зөрчилд 117 зөвлөмж, 483.9 сая төгрөгийн зөрчилд сахилгын хариуцлага тооцуулах 2 албан шаардлагыг өгсөн байна. Үүнээс шилэн дансны тухай хүүлийн хэрэгжилттэй холбоотой 8.380.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

**8.2. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах төлөвлөгөө гарган ажиллан, хэрэгжилтийг бодитой тооцон, биелэлтийг Төрийн аудитын газарт ирүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**



/Мян.төг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	27	22,145,367.1			27	22,145,367.1	27	22,145,367.1		
<b>Дүн</b>	<b>27</b>	<b>22,145,367.1</b>			<b>27</b>	<b>22,145,367.1</b>	<b>27</b>	<b>22,145,367.1</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/Мян.төг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
ТЕЗ	10	3,666,334.8			1		8	3,666,334.8	1	
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>3,666,334.8</b>			<b>1</b>		<b>8</b>	<b>3,666,334.8</b>	<b>1</b>	

Холбогдох байгууллагын санал:	Тайлбар
<p style="text-align: center;"> <b>МОНГОЛ УЛС</b> <b>ХӨВСГӨЛ АЙМГИЙН</b> <b>ЗАСАГ ДАРГА</b></p> <p style="text-align: center;">Адрес: Увс, Баян Мөнх, Уул, Хөвсгөл аймаг, 21101 Утас: 7758 2400, 7758 4024, факс: 7658 1100 Цахим хуудсант хуудсанд өгөгжүүлж байгаа сайтууд: <a href="http://www.mongol.gov.mn">www.mongol.gov.mn</a>, <a href="http://www.hovsgol.gov.mn">www.hovsgol.gov.mn</a></p> <p style="text-align: center;">2023.04.19 № 1/336</p> <p style="text-align: center;"><b>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ</b> <b>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</b></p> <p style="text-align: center;">Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй санал нэг байна.</p> <p style="text-align: center;">ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН</p> <p style="text-align: right;">67110104</p>	<p style="text-align: center;">Санал ирүүлээгүй.</p>



## Хавсрал №1

## Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга

дд	Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга	Гүйцэтгэсэн горим сорилын үр дүн (нөхцөл байдал)	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Залруулга хийсэн				Залруулга хийхэд үндэслэл болсон хууль тогтоомж, стандартын нэр, заалт	Тайлбар
				Санхүүгийн байдлын тайлан	Үр дүнгийн тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан	Өмчийн өөрчлөлтийн тайлан		
А	1	2	3	4			6	8	9
1	Авлага данстай холбоотой асуудал	Татаас санхүүжилтийн авлага дансны хоорондын тооцооны бичилтийг дугуу хийснийг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан. Үүнд: Мал хамгаалах сан 7,128,472.54 төгрөг, Байгаль орчин аялал жуулчлалын газар 127,243,712.0 төгрөг, Аймгийн Засаг даргын Тамгын газар 4,128,500.0 төгрөг	138,500,685	138,500,685				Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал	
2	Авлага данстай холбоотой асуудал	Дансны авлага /ТӨҮГ/ дансыг нэгтгэхдээ мөр мөрөөр нэгтгэх зарчмаар нэгтгээгүйгээс Могойн гол ХК-ийн дансны авлагын дүнг 170,481,000.0 төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн алдаа гарч аудитын хугацаанд залруулсан.	170,481,000	170,481,000				Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал	
